



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жадамбын ЭНХБАЯР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-22-13, Факс: 32-70-16
E-mail: enkhbayan@parliament.mn
http://www.parliament.mn

2016. 09. 11 № 3882

танай _____ -ны № _____ -т

Г

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн долдугаар зүйлийн 7.1.3-т заасан бүрэн эрхийнхээ дауу "Цахим бодлогын түр хороо" байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ж.ЭНХБАЯР

000091

Г
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА МИЕЭГОМБЫН
ЭНХБОЛД ТАНАА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жадамбын ЭНХБАЯР

14201 Улаанбаатар хот, Төрийн сүрье
Сүхбаатарын талбай б, Утас: 26-22-13, Факс: 32-70-16
E-mail: enkhbayar_1@parliament.mn
<http://www.parliament.mn>

2016. 04. 05 № 3593

таний _____ -ны № _____ -т

Г УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ц.ЦОЛМОН ТАНАА

Г Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх

хугацааг товлох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн долдугаар зүйлийн 7.1.3-т заасан бүрэн эрхийнхээ дауу "Цахим бодлогын түр хороо" байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.


Тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

Хавсралт 6 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Ж.ЭНХБАЯР



000084



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 18 он 03 дугаар
сарын 19.-ны өдөр

Дугаар XЭЛ
535


Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЭНХБАЯР ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн "Цахим бодлогын түр хороо байгуулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

010676

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС


Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэлд:

"ҮIII.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын санаачлан боловсруулсан "Цахим бодлогын түр хороо байгуулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төсөл


ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын санаачлан боловсруулсан "Цахим бодлогын түр хороо байгуулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.1-д "Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон дэд, түр хороо, нам, эвслийн бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ." гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 6.2-т "Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлagnadag байгууллагын үйл ажиллагааны тухай тогтоолыг холбогдох Байнгын хорооны түвшинд Улсын Их Хурлын гишүүд санаачилж болно." гэж тус тус заасан бөгөөд мөн хуулийн 12.2.10-т заасны дагуу уг хуулийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлал нь 6.2-т заасан дээрх тогтоолын төсөл боловсруулахад хамаarahгүй болно.

Иймд "Цахим бодлогын түр хороо байгуулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх боломжтой." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЭНХБАЯР

**“ЦАХИМ БОДЛОГЫН ТҮР ХОРОО” БАЙГУУЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТӨГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай цахим бодлогын асуудлыг шалган судалж, шийдлийн санал боловсруулах, дунг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хороог Улсын Их Хурлын тогтооюор байгуулан цахим шилжилтийн асуудлуудад төвлөрөн ажиллуулах шаардлагатай байна.

Дэлхийн улсууд цахим технологи ашиглан улсынхаа хөгжлийг хурдасгах, төрийн ажил хэргийг ил тод, нээлттэй, тунгалаг болгон төрөөс иргэдэд түргэн шуурхай үйлчлэх, төрийн үйлчилгээнд аливаа дарамт, хүнд суртал, авилгыг устган иргэдийн төрд итгэх итгэл үнэмшлийг бэхжүүлэх зэргээр улсын эдийн засаг, улс төр, нийгэм соёлын бүхий л асуудлыг хүртээмжтэй, шуурхай, шударгаар шийдэн, шинээр нэмүү өртөг шингэсэн, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүн боловсруулж баялаг бүтээн газар зүйн байршилаас үл хамааран дэлхийн зах зээлд нэвтрүүлэх талаар идэвхтэй ажиллан ашиг орлого олж, хөгжлийн шинэ тувшинд хүрч байгааг БНСУ, Япон, Эстони, Гүрж, ОХУ, БНХАУ, Израйль зэрэг олон улсын жишгээс харж байна.

Монгол Улс сүүлийн жилүүдэд цахим үйлчилгээг нэвтрүүлэх талаар зарим амжилт олж буйг “и-баримт”, “төрийн үйлчилгээний цахим машин” үйлчилгээнээс авч буй иргэдийн сэтгэл ханамж, зардлаа нөхөж ашиг олсон, татварын орлогыг нэмэгдүүлсэн, далд эдийн засгийг ил болгож төрийн үйлчилгээг шуурхай, хүнд суртал, авилгагүй, ил тод болгоход үзүүлсэн жишээнээс харж болно. Хэдийгээр ахиц дэвшил байгаа ч улсын аюулгүй байдлыг хамгаалах, баялаг бүтээх шинэ гарцыг үүсгэн, авилга, хүнд суртал, далд эдийн засгийг ил тод болгох, төрөөс үүдэлтэй нийгмийн стрессийг арилгах, цахим шилжилтийн хурдацыг нэмэгдүүлэх, бодлого, үйл ажиллагаа, хэрэгжүүлэлтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий “Цахим бодлогын түр хороо” байгуулах үндэслэл, зайлшгүй шаардлага үүсч байна.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоол нь 2 заалттай бөгөөд нэгд нь түр хорооны үндсэн чиг үүргийг тодорхойлон байгуулах, хоёрт нь тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тогтоох болно.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

"Цахим бодлогын түр хороо"-г байгуулах тогтоол батлагдсанаар үүсч болох улс төр, эдийн засаг, нийгэм, хууль зүйн дараах зерэг үр дүнд хүрнэ:

Нэг.Мэдээлэл технологи үүсч хөгжиж ирсэн өнөөгийн байдал, үүссэн зэрэг, сөрөг үр дагавар, улсын улс төр, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөө, хөгжлийн шинэ гарц, боломжуудыг судлан дүгнэлт, санал боловсруулж, хэрэгжүүлэх шийдлийг тодорхойлно.

Хоёр.Цахим шилжилт улсад хийх арга зам, эрх зүй, хөрөнгө оруулалтын асуудлыг судлан олон улсын зах зээлд шинэ ажил, бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломжийг судлан санал боловсруулна.

Гурав.Төрийн ажил, үйлчилгээг цахим засаглалын арга хэрэгслийг ашиглан ил тод, тунгалаг, хүртээмжтэй, хүнд сурталгүй, шуурхай болгох замаар авлига, далд эдийн засгаас салж, төрийн албыг цомхон, чадварлаг үр дүнтэй болгон хөгжүүлэх талаар санал гаргана.

Дөрөв.Мэдээлэл технологийн салбарын чиглэлийн хууль, эрх зүйг боловсронгуй болгох, ухаалаг, иргэндээ өгөөжтэй засаглал, улсын эдийн засаг, нийгэм, соёл, хүний хөгжилд зэрэг нөлөө үзүүлэх бодитой, хэмжигдэн үр дүн, ашиг гарахуйц санал боловсруулна.

Тав.Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд ахиц гарна.

Зургаа.Түр хороо нь иргэд, олон нийтийн байгууллага, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллага, дотоод, гадаадын шинжээчдийн дэмжлэг оролцоонд тулгуурласан санал, дүгнэлт боловсруулна.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хэрэгжүүлэх талаар цаашид шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар санал

Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай бүрэн нийцэж байгаа болно. Тогтоолын төсөлттэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Тогтоол санаачлагчид

“Цахим бодлогын түр хороо” байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулга

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай цахим бодлогын асуудлыг шалган судалж, шийдлийн санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хороог Улсын Их Хурлын тогтоолоор байгуулан цахим шилжилтийн асуудлуудад төвлөрөн ажиллуулах шаардлагатай байна.

Манай улсад мэдээлэл харилцааны технологи үүсч хөгжин улсын эдийн засаг, нийгэм, соёл, иргэдийн сэтгэлгээнд бодитой өөрчлөлт авчирсан ч хөгжлийн хурд, нөлөөлөл нь боломжит хэмжээ, хүрээнд хүрэхгүй байна.

Дэлхий дахинд мэдээлэл харилцааны технологи ашиглан газар зүйн байршил, хүний амын тоо, эдийн засгийн боломжоос төдийлөн хараат бусаар хөгжлийн шинэ эрэмбэд хүрсэн жишээ, загварыг ашиглан улсын эдийн засагт хөгжлийн шинэ гарц боломжийг үүсгэн баялаг бүтээх, төрийн ажил, үйлчилгээг ил тод, шуурхай, шударга болгох, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн албыг цомхон чадварлаг шуурхай болгох арга зам, дүгнэлт, санал боловсруулах зорилго бүхий “Цахим бодлогын түр хороо” байгуулах зайлшгүй шаардлага үүссэн гэж мэргэжлийн байгууллага, судлаачид, тогтоолын төсөл санаачлагч бид үзэж байна.

Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг нэгдсэн бодлого, зохицуулалт, хэрэгжилтээр хангах, цахим орчин дахь улсын иргэдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, дэлхийн зах зээлд нийлүүлэх шинэ ажил, үйлчилгээ, баялаг бүтээх боломжийг нэмэгдүүлэх тодорхой, хэмжигдэж, хэрэгжиж бодит үр дунд хүрэхүйц санал боловсруулах “Цахим бодлогын түр хороо”-г байгуулснаар дээрх асуудлууд зерэгзэр шийдэгдэнэ гэж үзэж тогтоолын төслийг боловсруулсан болно.

Тогтоол төсөл санаачлагчид

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Цахим бодлогын түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТӨГТООХ нь:

1. Төрийн үйл ажиллагааг цахимжуулах, цахим засаглал, цахим бодлого, түүнийг хөгжүүлэхтэй холбоотой нэгдсэн төлөвлөлт боловсруулах талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Цахим бодлогын түр хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

1. Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн
2. З.Нарантуяа Улсын Их Хурлын гишүүн
3. Л.Оюун-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн
4. Н.Учрал Улсын Их Хурлын гишүүн
5. Д.Цогтбаатар Улсын Их Хурлын гишүүн
6. Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн
7. Ж.Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь дагаж мөрдөнө.

Гарын үсэг